

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”-Т ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2022/22-03-ШТА-ГА

Баянхонгор хот 2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 99061861 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Аудитор Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 цахим хуудас: usukhbayarj@audit.gov.mn

Аудитор П.Амаржаргал

Утас: 88106992 цахим хуудас: amariargalp@audit.gmail.com



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
АУДИТЫН ДҮН	
ЗОРИЛТ НЭГ. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ НЭГДСЭН БОДЛОГО БАЙХГҮЙ БАЙНА.	
1.1. Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын засаглалын талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.	
1.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана гэсэн зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна.	
ЗОРИЛТ ХОЁР: ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД НЬ АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАЖ БАЙХАД АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.	
2.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.	
2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан ч зарим аж ахуйн нэгжийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.	
2.3. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь 2019-2021 онд нийт 1,416.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвийн хөрөнгийн үр өгөөж гараагүй байна.	
2.4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй байна.	
ЗОРИЛТ ГУРАВ: ОРОН НУТГИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	
3.1. Төрийн байгууллагуудаас санхүүгийн хяналтыг хангалттай түвшинд хэрэгжүүлж байгаа ч компанийн засаглал, үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.	
3.2. Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын болон дотоод хяналтын тогтолцоо төлөвшөөгүй, хяналтын үр дүнг тооцох боломжгүй байна.	
3.3. Шинээр үүсгэн байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлээгүй, түүнд тавих хяналт хангалтгүй байна.	
АУДИТЫН ДҮГНЭЛТ	
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБООУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББООУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТБОНӨААТҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББООУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТХХК	Цахилгаан түгээх хязгаарлагдмал хариуцлагатай компани



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу МУЕА-ын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны А/04 дугаар тушаалыг үндэслэн хийв.

**Аудитын
зорилт**

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг дүгнэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх.
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.

**Аудитын
хамарсан хүрээ**

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой дараах хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцдог хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн 2019-2021 оны үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, аймаг сумын ИТХ-ын тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагаас гаргасан шийдвэр, бусад хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд хамруулав. Үүнд:

Орон нутгийн өмчит “Чандмань-Баянхонгор” ХК, “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Баянхонгор аймгийн Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ, Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ, “Байшинтын таг” ОНӨҮГ, “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ зэрэг хуулийн этгээдийн 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулав.



**Аудитын арга
зүй**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт, АДБОУС-3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР3910, УДИР3920, Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан хамрагдагч байгууллагын ТУЗ, гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа болон судалгаа авах, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүй, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд:**

- Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Хууль

- Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2¹, 6 дугаар зүйлийн 6.2² дахь хэсэг /1992 он/
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/
- Компанийн тухай хууль /2011/
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Татварын ерөнхий хууль /2019/

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”
- УИХ-аас гаргасан холбогдох бусад тогтоол

Засгийн газрын тогтоол

- Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоол “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” -ийг тодотгон батлах тухай тогтоол
- Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоол “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг

¹ Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална

² Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.



Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Хүндрэл
бэрхшээл

хэрэгжүүлэх журам”

- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Засгийн газраас гаргасан бусад тогтоол, шийдвэрүүд

Бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд

- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Компанийн засаглалын зарчмууд”
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд
- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 тушаалаар баталсан “татвар төлөгчийн бүртгэх журам”
- ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчид үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт гэрээ байгуулах дүгнэх журам”
- Баянхонгор аймгийн 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого
- Баянхонгор аймгийн 2019-2021 оны ИТХ-ын тогтоол, сумдын ИТХ-ын тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамж
- Бусад холбогдох баримт

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, аудитор Ж.Өсөхбаяр, П.Амаржаргал, Б.Хүрэлчулуун нар хамтран гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөөг 2022.05.06-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2022.05.08-ны өдрөөс 2022.06.20-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2022.06.21-аас гүйцэтгэж, тайланг Газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2022.06.30-нд Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлэв.

Байхгүй



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд баталсан бөгөөд тус хуульд 29 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан. Тус үндэсний хөтөлбөрт “Компанийн засаглалын асуудлыг нийт компаниудын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны үндсэн зарчмуудад тулгуурлан хөгжүүлж, нээлттэй хувьцаат компани болон банк, төрийн өмчит компанийн онцлогт тохирсон нэмэлт шаардлага, шалгуурыг бий болгон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд бизнес эрхлэгч хувь хүнийг бизнесийн шударга ёс зүйтэй болгох, хуулийн этгээдийг олон улсад түгээмэл хэвшил болсон Компанийн засаглалын үндсэн зарчим, кодексыг үйл ажиллагаандаа баримталдаг болгох зорилтыг зэрэгцүүлэн тавьж хөгжүүлэх нь компанийн сайн засаглалыг хөгжүүлэх суурь үзэл баримтлал болно” гэж тодорхойлсон байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай үр дүнтэй явуулна”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж тус тус заасан

Баянхонгор аймгийн 2016 оны ИТХ-ын 15 дугаар хуралдаанаар “Баянхонгор аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ыг боловсруулан 5 зорилтыг дэвшүүлэн “Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэр хосолсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн, тээвэр логистикийн оновчтой бүтэц бүхий ногоон хөгжлийг эрхэмлэсэн, өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай, ядуурлаас бүрэн ангижирч, чинээлэг давхарга давамгайлсан, нэг хүнд ногдох орлого, эдийн засгийнхаа өсөлтөөр бүс нутагтаа тэргүүлсэн, иргэддээ сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн ухаалаг засаглалтай аймаг болно” хэмээн Алсын хараагаа тодорхойлсон байна.

Баянхонгор аймагт Авто тээврийн үндэсний төвийн “Баянхонгор аймаг дахь салбар”, Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Нисэх буудал”, орон нутгийн өмчит “Чандмань - Баянхонгор” ХК, “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Баянхонгор аймгийн Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ, Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ, Шинэжинст сумын “Тохижилт үйлчилгээний алба” ОНӨААТҮГ, Баян-овоо сумын “Байшинтын таг” ОНӨҮГ зэрэг хуулийн этгээдүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын урьдчилсан судалгаагаар 2021.12.31-ны өдрийн байдлаар орон нутгийн өмчит 8 хуулийн этгээдийн 49,078.6 сая төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд бүртгэлтэй байна.



АУДИТЫН ДҮН

ЗОРИЛТ НЭГ. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ НЭГДСЭН БОДЛОГО БАЙХГҮЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын засаглалын талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”, “Компанид засаглалын үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан байна. Тус аргачлалд заасны дагуу компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчийн эрх, нээлттэй ил тод байдал, ТУЗ-ын хүлээх үүрэг, хариуцлага, гүйцэтгэх удирдлага, оролцогч талууд гэсэн 5 ерөнхий үзүүлэлтийн хүрээнд 3 үе шатаар асуулга тус бүрд оноо өгч, нэгдсэн засаглалын үнэлгээний тайлан гаргах байдлаар засаглалыг үнэлж байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Компанийн тухай хуульд дээрх шалгуурыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байгаа эсэх талаар судлан шинжилгээ хийхэд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Хүснэгт 1. Хууль эрх зүйн уялдаа

Шалгуур үзүүлэлт	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	Компанийн тухай хууль
Хувьцаа эзэмшигчийн эрх	3 дугаар бүлэгт: Төрийн өмчийн удирдлага хэсэгт УИХ, Засгийн газар, ТӨБЗГ, холбогдох яамдын эрх, 9 дүгээр бүлэгт: орон нутгийн өмчийн талаарх ИТХ, Засаг даргын бүрэн эрхийг тусгасан.	Хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Нээлттэй ил тод байдал	ТБОНӨ-ийн тухай хуульд Мэдээллийн нээлттэй, ил тод байдлын талаарх зохицуулалт байхгүй ба Төрийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээд нь Мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар зохицуулагдаж байна.	Хуулийн 98 дугаар зүйлд Компанийн талаар мэдээлэл авах эрх үүргийг зохицуулсан.
ТУЗ-ын хүлээх үүрэг, хариуцлага	21 дүгээр зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх онцлог хэсэгт төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг томилох болон эрх, үүргийн талаар зохицуулсан.	Хуулийн 75 , 76 дугаар зүйлд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх үйл ажиллагааны талаар зохицуулсан.
Гүйцэтгэх удирдлага,	18, 19 дүгээр зүйлд ААТҮГ-ын захиргаа, захиралтай байгуулах гэрээний талаар зохицуулсан. 78 дугаар зүйлд ОНӨ-т хуулийн этгээдийн эрх баригчийг засаг дарга томилох эрхтэй байна.	Хуулийн 83 дугаар зүйлд гүйцэтгэх удирдлагын эрх үүргийг зохицуулсан байна.
Оролцогч талууд	Хуулийн зохицуулалт байхгүй	

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн талаарх эрх, үүрэг хяналт хариуцлагын талаар илүү зохицуулсан байгаа бол Компанийн тухай хуулийн 2



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

дугаар зүйлийн 2.5³-д зааснаар зөвхөн төрийн болон өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагааг тус хуулиар зохицуулахаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн нээлттэй ил, тод байдлын талаар зохицуулалтыг Мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар зохицуулсан байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, эрх үүргийн талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 -д зааснаар тус хуулиар төрийн болон өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагааг зохицуулахаар байгаа, ба төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг томилох болон эрх, үүргийн талаар зохицуулсан байна.

Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, эрх үүргийн талаар нарийвчилсан хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг үнэлэх тогтолцоо хангалтгүй байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-ын 3.2⁴-т Төрийн болон төрийн өмчит оролцоотой компани нь сайн дурын үндсэн дээр засаглалын үнэлгээг “Компанийн засаглалын үндэсний зөвлөл”-өөр хийлгэх зохицуулалттай байна.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс гаргасан Монгол Улсын компанийн засаглалын 2013, 2015 оны үндэсний тайланд зөвхөн төрийн өмчит компаниудаас засаглалын талаар судалгаа авч үнэлгээ хийсэн ба орон нутгийн өмчит компаниудын засаглалын талаар судалгаа үнэлгээ байхгүй байна.

Харин ОНӨААТҮГ болон УТҮГ-т засаглалын үнэлгээ хийх талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Цаашид орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг үнэлэх аргачлалыг боловсруулж мөрдүүлэх шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа хууль, тогтоомжид нийцүүлээгүй байна.

Аймгийн ИТХ болон сумдын ИТХ-ын тогтоолоор байгуулагдсан аудитад хамрагдсан орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс "Чандмань Баянхонгор" ХК -иас бусад нь 100 хувь орон нутгийн өмчит хуулийн этгээд байна.

Харин аймгийн ИТХ-ын 2012.10.11-ний өдрийн ээлжит бус XVIII хуралдаанаар “Чандмань- Баянхонгор” ХХК-ийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, хувьцааны 51 хувийг орон нутгийн өмчид, 20 хувийг ажилчдад эзэмшүүлж, 29 хувийг орон нутгийн иргэдэд арилжих шийдвэр гарч хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн баталж, 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн ч хувьцааг баталгаажуулж арилжаагүй байна.

³ Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

⁴ Облон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно”, 3.2.1 “Төрийн болон төрийн өмчит оролцоотой компани”



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Хүснэгт 2. ОНӨ-т хуулийн этгээдүүдийн эзэмшлийн хувь хэмжээ

№	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр	Статус	Өмчийн эзэмшлийн хувь	
			Орон нутгийн өмч	Бусад эзэмшигч
1	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	ОНӨХХК	100	
2	"Чандмань Баянхонгор" ХК	ОНӨХК	51	49
3	"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	ОНӨХХК	100	
4	"Цэвэр хот" ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	100	
5	"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	100	
6	Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ	УТҮГ	100	
7	"Байшинтын таг" ОНӨҮГ	ОНӨҮГ	100	
8	Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв" ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	100	
9	"Ингэн эрдэнэ" ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	100	

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Аймгийн үйлдвэржилтийн бодлогоор тодорхойлогдсон, зорилтот зах зээлд чиглэгдсэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд аймаг, орон нутгаас хөрөнгө оруулалт хийх, ажиллагсдын өмч, хөдөлмөрийн харилцаанд эзний сэтгэл бий болгох, иргэдээ өмчтэй болгох зорилгоор анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа компанийн хувьцааг ажиллагсдад нь үнэгүй хувьчлах эрх зүйн орчныг бий болгон хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн "Чандмань Баянхонгор", "Баянхонгор Эрчим хүч" ЦТ ХХК-уудыг хувьцаат компани болгоно" гэсэн зорилт дэвшүүлсэн байна.

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК нь өмчийн хэлбэрээ өөрчлөн хаалттай хувьцаат компани болох судалгааг хийсэн, "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 19.1⁵ -т заасны дагуу "Баянхонгор Чандмань" компанийг хувьцаат компани болгох боломжгүй болсон гэж тайлагнасан ба тус компанийн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зарчмаар ажиллаж ирсэн байна.

Аудитын явцад "Баянхонгор Чандмань" ХК-ийн захирал өгсөн тайлбартаа "...Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх, эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 3.1-т заасан холбогдох бичиг баримтыг бүрдүүлж Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.8-д заасны дагуу "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д бүртгүүлж гэрээ байгуулаагүй тул хаалттай хувьцаат компанийн шаардлагыг хангаагүй байгаа болно. Цаашид Санхүүгийн зохицуулах хороонд саналыг хүргүүлж албан ёсны хариу ирэхээр аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна." гэсэн болно.

Иймд үнэт цаасыг хуулийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, Компанийн үйл ажиллагаа, дүрмийн хууль эрх зүйн орчныг дахин хянаж, хуулийн зөрчлийг арилгах албан шаардлагыг "Баянхонгор Чандмань" ХК-ийн ТУЗ-д хүргүүлэв.

"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.04.01-ны өдрийн 48 дугаар тогтоолоор "Баянхонгор-Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ болгон өөрчлөн байгуулсан. Байгууллагын статусыг ОНӨААТҮГ болгон өөрчилсөн байхад 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа нь улсын төсөвт үйлдвэрийн газар буюу орон нутгийн төсвөөс санхүүжилт аван санхүүгийн тайлан нь төсөвт байгууллагаар тайлагнасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2⁶-т дахь заалтыг зөрчсөн ба тус зөрчилтэй холбоотой санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.

⁵ Хот суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх бохир ус татан зайлуулах цуглуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна

⁶ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

“Цэвэр хот” ХХК-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.12.25-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор “Цэвэр хот” ОНӨААТҮГ болгосон.

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох хог хаягдлын хураамжийн орлого нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12⁷, Хог хаягдлын тухай хуулийн 41.8⁸ дахь заалтын дагуу Баянхонгор сумын төсвийн орлогод төвлөрч, Баянхонгор сумын төсвөөс үйл ажиллагааны санхүүжилтийг авч байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг архидан согтуурах, мансуурах, тоглоомд донтох, стресст өртөх зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг тандах, судлах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх зорилгоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулж орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 250.0 сая төгрөгийн санхүүжилт авч цаашид зардал нэмэгдэхэд орон нутгийн төсөвт хүндрэл учрах эрсдэлтэй байна.

Иймд тус байгууллагыг эрүүл мэндийн салбарт шилжүүлэх асуудлыг судалж үзэхийг аймгийн ИТХ-д зөвлөв.

Аудитын илрүүлэлт:

“Шинэжинст тохижилт үйлчилгээний алба”-ыг Шинэжинст сумын Засаг даргын 2019.01.07-ны өдрийн А/02 тоот захирамжаар үүсгэн байгуулсан ч УТҮГ-ын ажиллах дүрмийг сумын ИТХ-аар батлуулаагүй, сумын Засаг дарга эрх үүрэгээ хэтрүүлэн орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгуулж төрийн эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн баримт бичиг хоорондын уялдааг хангаж, чиг үүрэгээ зохистой түвшинд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалтыг зөрчсөн, мөн тус байгууллага нь улсын бүртгэлд Улсын төсөвт үйлдвэрийн газраар бүртгүүлсэн байгаа боловч 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн загвараар гаргасныг санхүүгийн тайлангийн аудитаар залруулж зөрчлийг арилгасан болно.

Иймд төрийн эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн баримт бичиг хоорондын уялдааг хангаж, чиг үүрэгээ зохистой түвшинд хэрэгжүүлж үүсгэн байгуулаагүй “Шинэжинст тохижилт үйлчилгээний алба” УТҮГ-ыг татан буулгах албан шаардлагыг Шинэжинст сумын Засаг даргад хүргүүлэв.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг бүртгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлага хангасан эсэхийг хянаж байх зөвлөмжийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.03.09-ны өдөр “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 11 дүгээр тогтоолоор сумын Засаг дарга санал болгосноор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулсан байна.

Байшинтын таг ОНӨААТҮГ-ыг Төрийн банк дахь 230500077099 тоот дансаар уул уурхайн компани болон нөхөрлөлүүдээс дараах орлого орсон байна.

Хүснэгт 3. “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ын дансанд төвлөрсөн орлого		/сая төгрөг/
№	Байгууллагын нэр	Мөнгөн дүн
1	Наранмандал Этэрпрайзес ХХК	313.0
2	Алтан ус ХХК	50.0
3	Дулаан наран ХХК	50.0
4	Нөхөн сэргээлтийн барьцаа Буяндэлгэр нөхөрлөл	6.0
5	Шинэ дэвшил нөхөрлөл	3.0
6	Үйл ажиллагааны орлогоос гэрээнд заагдсан ашгийн 30 хувь болох төлбөр Буяндэлгэр нөхөрлөл	4.0
7	Шинэ дэвшил нөхөрлөл	1.7

⁷ хог хаягдлын үйлчилгээний хураамж

⁸ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

№	Байгууллагын нэр	Мөнгөн дүн
8	бусад орлого	1.5
Нийт		429.2

Эх сурвалж: 2022 оны 02 дугаар сарын 08-18-ны өдрүүдийн хооронд аймгийн СХАА-наас хяналт, шалгалтын материал, Байшинтын таг ОНӨААТҮГ-ын Төрийн банкны 230500077099 тоот дансны хуулга

Аудитын явцад Байшинтыг таг ОНӨААТҮГ-ын ажиллах дүрмийг нотлох баримтаар ирүүлээгүй бөгөөд орлого бүрдүүлэлт өөрийгөө хэрхэн санхүүжүүлэх талаар нотлох боломжгүй байна.

Баян-Овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хурлын хуралдааны 03/14 дугаар тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, бусад урсгал үйл ажиллагааны зардлуудыг 2 дугаар хавсралтаар баталсан байна. Хавсралтаар батлагдсан ажил, төсөл хөтөлбөртэй холбоотой үйл ажиллагаанд АТГ-ын шалгалт хийгдэж байгаа бөгөөд шалгалтын үр дүн одоогоор гараагүй байгаатай холбоотой нотлох баримтыг татан авч үзэх боломжгүй байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2021.12.21-ний 06/13805 дугаар албан бичгийн дагуу санхүүгийн баримтуудад албан бичгийн хавсралтад тусгасан асуудлуудын хүрээнд 2022 оны 02 дугаар сарын 08-18-ны өдрүүдийн хооронд аймгийн СХАА-наас хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

“Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/06 тоот Баян-Овоо сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн тогтоолоор татан буулгасан байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлоогүй, санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг хийгээгүй, сумдад ОНӨААТҮГ байгуулан уул уурхайн компаниудаас их хэмжээний хөрөнгө төвлөрүүлэн зарцуулж байгаа нь эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын ашиг сонирхлын зөрчил үүсэх томоохон шалтгаан болох эрсдэл үүсэж байна.

Иймд цаашид Сум орон нутагт хууль зөрчин үр ашиггүй орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж уур уурхайгаас хандивын орлогыг төвлөрүүлэн зарцуулдаг байдлыг таслан зогсоох, орон нутагт ямар нэгэн хэлбэрээр орж байгаа хандивын орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-д төвлөрүүлж байх зөвлөмжийг сумдын ИТХ-ын даргад хүргүүлэв.

1.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана гэсэн зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого байхгүй байна.

Баянхонгор аймгийн 2016 оны ИТХ-ын 15 дугаар хуралдаанаар “Баянхонгор аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ыг боловсруулан 5 зорилтыг дэвшүүлэн “Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон **эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэр хосолсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн**, тээвэр логистикийн оновчтой бүтэц бүхий ногоон хөгжлийг эрхэмлэсэн, өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай, ядуурлаас бүрэн ангижирч, чинээлэг давхарга давамгайлсан, нэг хүнд ногдох орлого, эдийн засгийнхаа өсөлтөөр бүс нутагтаа



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

тэргүүлсэн, иргэддээ сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн ухаалаг засаглалтай аймаг болно” хэмээн алсын хараагаа тодорхойлсон байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхойлсон 5.2.1. дэх “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.” гэсэн зорилт, “Баянхонгор аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын хүрээнд дараах орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд аймаг, сумын ИТХ-ын холбогдох тогтоол шийдвэрээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Хүснэгт 4. **ОНӨ-т хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан орон нутгийн бодлого шийдвэр**

№	Баянхонгор аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогын зорилт	Үр дүн
1	“Төсөл хөтөлбөрүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Баянхонгор Хөгжлийн корпорац-ХХК-ийг байгуулах, аймаг орон нутагт үйлдвэрлэх төсөл хөтөл боловсруулсан жижиг дунд бизнес эрхлэгчдэд ажилсаг төвийн барилгыг түшиглэн Баянхонгор үйлдвэр технологийн парк-ийн бизнес инкубатор төвд бойжуулах.	Аймгийн ИТХ-ын 2016 оны 3/2 дугаар тогтоолоор “Баянхонгор Хөгжлийн корпорац-ХХК-ийг байгуулсан.
2	Сүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, бус нутгийн мал сүргийг өндөр ашиг шимтэй малаар сайжруулж, сүү үйлдвэрлэлийн бүс нутгуудад бэлтгэсэн сүүг уламжлалт технологи ашиглан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, олон нэр төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав баглаа боодолжуулах, дотоод гадаадын зах зээлд нэвтрүүлэх үйл ажиллагааг кластерийн зохион байгуулалтаар хөгжүүлж хуурай сүүний үйлдвэр байгуулах	Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/7 дугаар тогтоолоор “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ийг байгуулсан боловч үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.
3	Иргэддээ мод, бут, зүлэг цэцэг тариалах, байгаль орчноо нөхөн сэргээх, эрүүл орчин бүрдүүлэх, сумын төв, Баянхонгор хот суурин газруудыг ногоон хот болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа байгууллага, айл өрх, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгох.	Аймгийн ИТХ-ын 2016.09.28-ны өдрийн 85 дугаар тогтоолоор Хот тохижилт - үйлчилгээ ОНӨҮГ-ыг “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНТҮГ, “Цэвэр хот” ОНӨХХК болгон үйл ажиллагааны чиглэлээр хоёр болгон өөрчилсөн.
4	Хот суурин газруудын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх, ДЦС барих, гэр хорооллыг орон сууцжуулах замаар утаагүй орчныг бүрдүүлэх, орон нутгийн түлшний хэрэгжээг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байгаль орчинд ээлтэй эко түлшээр бүрэн хангах	

Засгийн газрын 2016 оны “Бүтэц шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2016 оны А/633 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны алба, орон нутгийн өмчийн албуудыг нэгтгэж Орон нутгийн өмчийн газрыг байгуулсан байна.

Тус газар нь орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, орон нутгийн өмчийн бүрэн бүтэн байдал, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд орон нутгийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийг судлан боловсруулж шийдвэрлүүлэх, орон нутгийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах, шинээр авах харилцааг хариуцах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Харин төрийн өмчийн хуулийн этгээд байгуулахад ТӨБЗГ-аар хянуулж байхад орон нутгийн түвшинд орон нутгийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулахад ОНӨГ нь хяналт тавьж оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 4 байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан ба 5 байгууллагад төлөөлөн удирдах зөвлөл байхгүй байна.

Хүснэгт 5. ОНӨ-т хуулийн этгээдийн ТУЗ-ын судалгаа

№	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр	ТУЗ байгаа эсэх	ТУЗ-ын гишүүдийн тоо	Өмчийн эзэмшлийн хувь		
				ИТХ-ын төлөөлөгч	Төрийн албан хаагч	Хараат бус гишүүн
1	2	3	4	5	6	7
1	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	Тийм	11	7	1	3
2	"Чандмань Баянхонгор" ХК	Тийм	9	4	2	3
3	"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	Тийм	9	4	2	3
4	"Цэвэр хот" ОНӨААТҮГ	Тийм	9	6	2	1
5	"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	Үгүй	-	-	-	-
6	Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ	Үгүй	-	-	-	-
7	"Байшинтын таг" ОНӨААТҮГ	Үгүй	-	-	-	-
8	Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв" ОНӨААТҮГ	Үгүй	-	-	-	-
9	"Ингэн эрдэнэ" ОНӨААТҮГ	Үгүй	-	-	-	-
	Нийт дүн					

"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв" ОНӨААТҮГ-ын дүрэмд төлөөлөн удирдах зөвлөл байгуулах тухай заалт байхгүй, "Байшинтын таг" ОНӨААТҮГ, Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ-уудын үйл ажиллагааны дүрмийг батлаагүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 126 тогтоолоор байгуулсан "Цэвэр хот" ОНӨААТҮГ -ын ТУЗ нь 2021 онд дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа явуулаагүй тул 2021.12.28-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор ТУЗ-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна.

"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК, "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-уудын төлөөлөн удирдах зөвлөл нь жилд 1-3 удаа хуралдан компанийн бизнес төлөвлөгөө батлах, тодотгол оруулах, биелэлтийг сонсох зэрэг шийдвэр гаргасан байгаа ба Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11⁹, 76.1.13¹⁰ -т заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ТУЗ-ийн нэг гишүүнд "Баянхонгор эрчим хүч" ЦТХХК 174,000 төгрөг, "Чандмань Баянхонгор" ХК 150,000 төгрөгийн урамшууллыг сар бүр олгож байгаа бол "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК 55,000 төгрөгийн урамшууллыг улирал бүр олгож байна.

ТУЗ-ийн гишүүдэд 2019-2021 онд "Баянхонгор эрчим хүч" ЦТХХК нийт 73.1 сая, "Чандмань Баянхонгор" ХК нийт 40.3 сая, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК нийт 2.5 сая төгрөгийн урамшуулал олгосон нь дээрх үүргээ бүрэн биелүүлээгүй, урамшууллыг ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан олгох эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

⁹ компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

¹⁰ төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Хүснэгт 6. ОНӨ-т хуулийн этгээдийн ТУЗ-д 2019-2021 онд олгосон урамшуулал

сая.төг

	Компанийн нэр	2019	2020	2021	НИЙТ
1	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	27.7	20.6	24.8	73.1
2	"Чандмань Баянхонгор" ХК	12.6	13.0	14.7	40.3
3	"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	0.3	0.9	1.3	2.5
	Нийт	40.6	34.5	40.8	115.9

Мөн Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх 3 хороог байгуулсан байгаа ч хороод нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаар хангалттай баримт байхгүй байна.

Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүн, нарийн бичгийн дарга нар нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаагүй байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8¹¹ дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийг хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, үр дүнг тооцож байх зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад, ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргыг компанийн засаглалын сургалтад хамруулах зөвлөмжийг компаниудын ТУЗ-ийн дарга нарт хүргүүлэв.

ЗОРИЛТ ХОЁР: ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД НЬ АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАЖ БАЙХАД АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.

2.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.

"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК, "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК нь жил бүр бизнес төлөвлөгөөг өмнөх жилүүдийн орлого, зарлагын гүйцэтгэл, эрх бүхий байгууллагаас батлагдсан үнэ тариф, бүтэц орон тоонд суурилан боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 7. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны орлого, зарлагын төлөвлөгөө

сая.төг

Хуулийн этгээдийн нэр	2019 он			2020 он			2021 он		
	Орлого	Зардал	Ашиг алдагдал	Орлого	Зардал	Ашиг алдагдал	Орлого	Зардал	Ашиг алдагдал
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	8,729.2	8,729.2	-	9,289.8	9,289.8	-	1,132.0	1,132.0	-
"Чандмань Баянхонгор" ХК	1,586.7	1,513.7	73.0	1,991.4	1,981.5	9.9	2,037.7	2,136.5	(98.9)
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	100.3	297.8	(197.5)	202.9	384.3	(181.4)	228.9	384.3	(155.4)

Тус байгууллагуудын 2019-2021 оны бизнес төлөвлөгөөг нийт 550.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Харин "Цэвэр хот" ОНӨААТҮГ, "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь төсвийн төслийг боловсруулан аймгийн ЗДТГ-ын СТСХ-д хүргүүлж "Цэвэр хот" ОНӨААТҮГ -ын төсвийг Баянхонгор сумын ИТХ, "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ -ын төсвийг аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж байна.

¹¹ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Хүснэгт 8. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны орлого, зарлагын төлөвлөгөө

сая.төг

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төсвийн төсөл	Батлагдсан	Төсвийн төсөл	Батлагдсан	Төсвийн төсөл	Батлагдсан
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	870.7	637.5	1,088.9	640.6	858.8	640.5
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	515.4	510.3	535.7	535.7	700.0	700.0

Тус байгууллагууд нь төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэлд суурилан боловсруулж байгаа ба "Цэвэр хот" ОНӨААТҮГ нь хог хаягдлын хураамжийн орлого, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтээр орлогыг төлөвлөж байгаа бол "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжихээр төлөвлөлтийг хийсэн.

Тухайлбал: "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь байгаль орчин нөхөн сэргээх, хамгаалах зардалд 338.2 сая төгрөгөөр төлөвлөж 103.3 сая төгрөгөөр баталсан. цалин, НДШ-ийн зардлыг 387.4 сая төгрөгөөр төсөвлөснөөс 368.5 сая, урсгал засварын зардлыг 127.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 30.0 сая төгрөгөөр баталсан байна. 2021 оны төсвийн төслийг 858.8 сая төгрөгөөр хүргүүлж 640.5 сая төгрөгөөр батлагдсан.

Цалин, НДШ-ийн зардлыг 421.0 сая төгрөг, байгаль орчин нөхөн сэргээх зардалд 76.4 сая, ашиглалтын зардлыг 93.3 сая төгрөгөөр төсвийн төслийг хүргүүлсэн байхад цалин, ндш 368.5 сая, нөхөн сэргээх зардал 103.2 сая, ашиглалтын зардал 57.8 сая төгрөгөөр зардлын төсвийг баталж байгаа нь төсвийн төслийг бодитойгоор төлөвлөхгүй байна.

Харин Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21.2¹²-т заасан зорилтыг төлөвлөхгүй байгаагаас 21¹ дүгээр зүйлийн 21.1¹³ дахь заалт огт хэрэгжихгүй байна.

Энэ талаар мөн тус компаниудын дүрэмд тусгаж өгөөгүйгээс орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь байгууллагын хэтийн зорилт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ, санхүүгийн төлөв, төлөвлөж буй ашиг, төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг, төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт зэргийг дунд хугацаандаа орон нутгийн бодлого шийдвэрт нийцүүлэн төлөвлөж төрийн байгууллагаар хянуулах үйл ажиллагаа хийгдэхгүй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21.2-т заасан зорилтын саналыг 21¹ дүгээр зүйлийн 21.1-т заасан хугацаанд аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж байх албан шаардлагыг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21.3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

¹² Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана:

- 1/байгууллагын 3 жилийн хэтийн зорилт;
- 2/үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ;
- 3/нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримталсан бодлогын тухай тайлбар;
- 4/санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг;
- 5/төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг;
- 6/төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт.

¹³ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж, батлагдсан төлөвлөгөөг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж байна.

"Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ууд нь эдийн засгийн зорилтот түвшин буюу бизнес төлөвлөгөөг нэг жилийн хугацаатай боловсруулан компанийн ТУЗ-өөр батлуулж байна.

Аудитын илрүүлэлт:

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн 2021 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ-аар батлуулаагүй, төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийг гаргаж ТУЗ-аар хэлэлцүүлэн үр дүнг тооцуулаагүй байна.

Цаашид компанийн бизнес төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцэн баталж, бизнес төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж үр дүнг тооцож байх албан шаардлагыг "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн ТУЗ-д өгөхөөр шийдвэрлэв.

Харин "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГ нь эдийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө боловсруулаагүй зөвхөн төсөвт байгууллагын статусаар төсвийн төсөл боловсруулан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээр хянуулж аймаг, сумын ИТХ-аар батлуулсан байна.

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан ч зарим аж ахуйн нэгжийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 2019-2021 онд нийт 26,788.2 сая төгрөгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого олохоор батлагдаж гүйцэтгэлээр 39,793.0 сая төгрөг оруулсан байна.

Хүснэгт 9. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

Хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	8,729.2	9,584.6	9,289.8	10,588.9	11,320.3	11,545.7
"Чандмань Баянхонгор" ХК	1,586.7	1,832.9	1,991.4	1,848.3	2,037.7	2,195.1
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	100.3	109.7	202.9	181.8	228.9	170.1
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	430.3	424.4	490.0	523.4	550.0	524.7
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	6.0	12.8	8.0	6.4	5.0	1.7
Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ				45.6		196.8
Нийт	10,852.5	11,964.4	11,982.1	13,194.5	14,141.9	14,634.1

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК:

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК нь 2019-2021 онд нийт 498.4 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 461.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 10. "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	2019 он /сая.төг/		2020 он /сая.төг/		2021 он /сая.төг/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Түрээсийн орлого	81.9	84.0	98.8	93.1	123.1	105.9
Түрээсийн хөнгөлөлт /санхүүгийн дэмжлэг/	-	5.6	80.0	80.0	80.0	50.0
Бусад	18.4	20.1	1.5	8.6	14.7	14.2
НИЙТ	100.3	109.7	180.3	181.8	217.8	170.1

Нийт орлогын 60 хувийг түрээсийн орлого эзэлж байгаа ба төлөвлөсөн орлогын 93.2 хувийг бүрдүүлсэн байна.

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар тогтоолоор ажилсаг төв, ахуйн үйлчилгээний төвийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагын түрээсийн төлбөр, хөнгөлөлийн жишиг үнийг баталсны дагуу 2020 оноос хөнгөлөлттэй үнээр



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

түрээсийн төлбөрийг тооцсон ба 2020-2021 онд түрээсийн хөнгөлөлтөөс 156.6 сая төгрөгийн орлого алдсан байна.

Хүснэгт 11. "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн түрээсийн төлбөрийн судалгаа

Утга	Хэмжих нэгж	Үндсэн үнэ	Хөнгөлөлттэй үнэ
Ахуйн үйлчилгээний төв			
1, 2 давхар	1 мкв	15000	8800
B1 давхар	1 мкв	10000	6600
Үйлдвэр үйлчилгээний "Ажилсаг" төв			
Үйлдвэрлэл үйлчилгээнд	1 мкв	15000	5500
Бусад	1 мкв	10000	4950

Аудитын явцад түрээсийн объектүүдийг газар дээр нь танилцахад ахуйн үйлчилгээний төв 128.2м², "Ажилсаг" төвд 220.8м² талбайг түрээслээгүй ашиглалтгүй байна.

Цаашид ахуйн үйлчилгээний төв болон үйлдвэр үйлчилгээний "Ажилсаг" төвийн түрээслэх боломжит ашигтай талбайг ТУЗ-өөс тогтоосон үндсэн үнээр тооцвол жилийн борлуулалтын орлогыг 197.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүснэгт 12. "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн түрээсийн орлогын тооцоолол

Түрээсийн объектын байршил	Жилийн борлуулалтын орлого /сая.төг/		
	Хөнгөлөлттэй үнээр	Үндсэн үнээр	Орлого нэмэгдэх боломж
Ажилсаг төв	95.1	249.1	154.0
Ахуйн үйлчилгээний төв	66.1	109.4	43.3

Иймд цаашид компанийн ашигт ажиллагаа, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор түрээсийн төлбөрийн талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмжийг "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Үйлдвэрлэл үйлчилгээний "Ажилсаг" төв дээр үйл ажиллагаа явуулдаг "Өсөн дэвжих хонгор" ХХК нь 2021.01.20-ы өдөр байгуулсан ТГ-21/38 тоот түрээсийн гэрээгээр 78.5м² талбай түрээсэлж байгаа ч аудитын явцад газар дээр нь шалгахад 171.95м² талбай буюу гэрээнд зааснаас 93.45 м² талбай илүү түрээсэлж байна.

Иймд илүү түрээсэлсэн талбайн 2021 оны 01 сараас 2022 оны 05 сар хүртэлх хугацааны зөрүү 8.7 сая төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Бусад орлогоор 2019-2021 онд нийт 34.6 сая төгрөг орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 43.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг биелүүлсэн байна.

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн хөнгөлөлттэй зээл авсан зээлийн үлдэгдэл 2022.05.25-ы өдрийн байдлаар 132 зээлдэгчийн 1,792.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 48 зээлдэгчийн 746.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байгаа ч 26 зээлдэгчийн 36.8 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ аваагүй байна.

Аудитын илрүүлэлт:

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-аас олгосон зээлийн үлдэгдлээс 746.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байгаагаас 26 зээлдэгчийн 36.8 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ аваагүй байна.

Иймд хугацаа хэтэрсэн зээлүүдийг буцаан төлүүлэх, төлөөгүй зээлдэгчдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

"Чандмань Баянхонгор" ХК:



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

"Чандмань Баянхонгор" ХК нь 2019-2021 онд нийт 5,615.7 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,876.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 13. "Чандмань Баянхонгор" ХХК-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төг

"Чандмань Баянхонгор" ХХК	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Цэвэр усан хангамж	565.3	565.2	572.0	595.1	657.5	658.8
Ариутгах татуурга	325.0	343.0	347.7	361.9	412.9	411.0
Дулаан хангамж	542.4	570.4	600.3	581.6	607.8	675.6
Суурь хураамж	86.4	93.4	93.4	102.1	112.0	110.5
Ус түгээх байгууламж	56.5	80.2	77.9	101.1	196.1	240.0
Бусад	11.1	180.6	300.0	106.5	51.3	99.3
НИЙТ	1,586.7	1,832.9	1,991.4	1,848.3	2,037.7	2,195.1

Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 2019, 2021 онуудад бүрэн биелүүлж ажилласан ч 2020 онд нийт орлогын төлөвлөгөө 143.1 сая төгрөгөөр дутуу биелсэн байгаа ба энэ нь дулаан хангамж болон үйл ажиллагааны бусад орлого биелээгүйтэй холбоотой байна. Тухайлбал:

Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс 2020 оны дулааны тарифыг 1620 төгрөг болгож нэмэгдүүлсэн ба тус тарифаар орлогыг төлөвлөсөн ч Ковид-19 цар тахалтай холбоотой аймгийн Засаг даргын захирамжаар тус байгууллагын уурын зуухнаас халаалт авдаг төв захын бизнес эрхлэгчдийн дулааны тарифыг хуучин тариф буюу 1500 төгрөгөөр тооцох шийдвэр гарсантай холбоотой дулаан хангамжийн борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Бусад орлогын төлөвлөгөөнд Баянхонгор сумын 5 дугаар багийн төвийн шугам сүлжээний 250.0 сая төгрөгийн ажлыг 2020 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ч тус шугам сүлжээний ажил хийгдээгүй тул бусад орлогын төлөвлөгөө 193.5 сая төгрөгөөр биелээгүй байна.

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК:

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК нь 2019-2021 онд нийт 29,339.3 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 31,719.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж борлуулалтын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 14. "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төг

Орлогын нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Борлуулалтын орлого	5,955.9	6,211.9	6,471.6	7,494.5	8,036.9	8,391.9
Хангах үйлчилгээний орлого	2,617.7	2,617.7	2,658.2	2,658.2	3,153.7	2,884.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	155.6	755.0	160.0	436.2	129.7	269.3

"Цэвэр хом" ОНӨААТҮГ

Баянхонгор сумын ИТХ-ын хуралдааны 2019 оны "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай" 12/12 дугаар тогтоолоор ахуйн хог хаягдлын хураамжийн хэмжээг, аймгийн ИТХ-ын 2019 оны 24 дүгээр тогтоолоор орон сууцны орц цэвэрлэгээний хураамжийг хэмжээг тус тус тогтоосон.

Баянхонгор сумын ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 2019-2021 онд 430.0-550.0 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 2019 онд 424,4 сая төгрөг /99 хувь/, 2020 онд 523.4 сая төгрөг /107 хувь/ ийг Баянхонгор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Хүснэгт 15. "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төг

Орлогын нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хог хаягдлын хураамж	430.3	424.4	490.0	523.4	550.0	524.7

Айл өрхийн хог хаягдлын хураамжийн орлогыг Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-тай 2019 оны 04 сарын 05-ны өдөр "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан ба тус гэрээгээр хог хаягдлын хураамжийн орлогыг цахилгааны төлбөрийн хамт нэхэмжлэн авсан хог хаягдлын хураамжийн орлогын 10 хувийг Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-д олгохоор гэрээнд тусгасан. Дээр борлуулалтын шимтгэлийн зардал 10 хувийг Цэвэр хот ОНӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлд орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байна.

Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний" тухай тогтоолын 1-д "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020.12.1-ний өдрөөс тооцож 2021.12.31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх" гэж тусгасан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2021 онд 617.3 сая төгрөгийн хог тээврийн хөнгөлөлтийг аймгийн орон нутгийн төсөвт олгосноос 70.6 хувь буюу 435.9 сая төгрөгийг Баянхонгор суманд олгосон нь өмнөх оны мөн үеийн хог хаягдлын хураамжийн орлогын гүйцэтгэлээр олгосон байна.

2.3.Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь 2019-2021 онд нийт 1,416.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвийн хөрөнгийн үр өгөөж гараагүй байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг хийж түүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллахгүй байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь 2019-2021 онд нийт 1,416.3 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байгаа ч компанийн гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо дүн шинжилгээ хийж түүнд чиглэсэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хүснэгт 16. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны ашиг, алдагдал

сая.төг

Хуулийн этгээдийн нэр	2019 он	2020 он	2021 он	НИЙТ
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	(95.0)	5.5	(415.8)	(505.2)
"Чандмань Баянхонгор" ХК	137.8	(133.2)	61.9	66.6
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	(201.7)	(165.0)	(246.3)	(613.0)
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	(88.8)	(59.9)	49.3	(99.4)
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	296.8	(22.1)	(610.5)	(335.8)
Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ	-	(5.5)	76.0	70.5
НИЙТ ДҮН	49.2	-380.2	-1085.3	-1,416.3

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК:

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК нь 2019-2021 онд 165-246 сая төгрөгийн алдагдалтай буюу жил бүр алдагдалтай ажиллаж ирсэн байна. Мөн 2019-2021 онд орон нутгийн төсвөөс нийт 135.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Тус байгууллага нь үйлдвэрлэл үйлчилгээний “Ажилсаг” төв, ахуйн үйлчилгээний төв гэсэн объектийг түрээслүүлэн түрээсийн орлого олж байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого бөгөөд тус объектуудээс 150.0-180.0 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Хүснэгт 17. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн объектуудийн ашиг, алдагдал сая.төг

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он
Түрээсийн цэвэр орлого -Ажилсаг төв	53.1	50.0	64.1
Түрээсийн цэвэр орлого -Ахуйн үйлчилгээ	6.2	44.2	41.9
Үйл ажиллагааны зардал-Ажилсаг төв	214.2	211.0	217.0
Үйл ажиллагааны зардал-Ахуйн үйлчилгээ	11.6	63.7	38.8
Ашиг алдагдал-ажилсаг төв	(161.1)	(161.0)	(152.9)
Ашиг алдагдал-ахуйн үйлчилгээ	(5.3)	(19.5)	3.0

Тус 2 объекттай холбоотой жилд 173.4-233.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэж байгаа нь дээрх алдагдлын гол нөлөөг үзүүлж байгаа ч тус 2 объектын түрээслэх боломжит ашигтай талбайг ТУЗ-өөс тогтоосон үндсэн үнээр тооцвол жилийн борлуулалтын орлогыг 197.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж алдагдлыг бууруулж төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг гаргах боломжтой байна.

Иймд цаашид компаний алдагдлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлэх судалгаа шинжилгээ хийж, дунд болон богино хугацааны стратеги төлөвлөгөө гарган орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах зөвлөмжийг ТУЗ-д өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын илрүүлэлт:

Ахуйн үйлчилгээний төвийн барилгын анх баригдсан өрөөнүүдийн зохион байгуулалтыг өөрчилсөн тул одоо байгаа өрөөнүүдийн хэмжээг тогтоож баталгаажуулсан зураг байхгүй, түрээсийн талбайг бодитой тооцож байгаа эсэхийг нотлох боломжгүй байна.

Иймд барилгын талбайн хэмжилтийн зургийг хийлгэж түрээслэгчидтэй байгуулсан талбайн хэмжээг баталгаажуулах зөвлөмжийг компанийн гүйцэтгэх удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

“Чандмань Баянхонгор” ХК:

“Чандмань Баянхонгор” ХК нь 2019, 2021 онуудад 61.9-137.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байгаа боловч 2020 онд 133.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тус байгууллага нь цэвэр усан хангамж, ариутгах татуурга, зөөврийн усан хангамж, дулаан үйлдвэрлэл гэсэн үндсэн үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба дулаан үйлдвэрлэлээс нийт 194.3 сая, спорт заалнаас 32.2 сая төгрөгийн алдагдал хүлээсэн нь нийт ашигт ажиллагааны түвшинг бууруулахад голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 18. “Чандмань Баянхонгор” ХХК-ийн 2019-2021 оны ашиг, алдагдал сая.төг

Объектын төрөл	2019 он	2020 он	2021 он
Цэвэр усан хангамж	16.5	(41.5)	33.7
Ариутгах татуурга	39.1	29.1	54.4
Зөөврийн усан хангамж	(23.8)	(20.7)	34.6
Дулаан үйлдвэрлэл	29.7	(124.4)	(99.6)
Спорт заал	0.2	(15.2)	(17.3)
Үндсэн бус үйл ажиллагаа	76.1	39.5	56.1
НИЙТ АШИГ, АЛДАГДАЛ	137.8	(133.2)	61.9



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Дулаан үйлдвэрлэлээс 2019 онд 29.7 сая төгрөгийн ашигтай ажилласан ч 2020 оноос алдагдалтай ажилласан нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 48 дүгээр тогтоолоор Хонгор-1000 хорооллын 3.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий одоогоор ашиглалтгүй байгаа инженерийн шугам, сүлжээг хүлээн авч бүртгэн жил бүр 207.8 сая төгрөгийн элдэгдлийн зардлыг байгуулж бүртгэсэнтэй холбоотой байна.

Иймд дээрх бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглалтгүй байгаа 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн үр ашгийг гаргаж эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

“Чандмань Баянхонгор” ХК-ийн 2012-2014 оны хооронд хэрэгжсэн Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөлтэй холбоотой 4,818.2 сая төгрөгийн зээлээр хэрэгжүүлсэн инженерийн шугамж сүлжээ аймгийн орон нутгийн өмчид бүртгэлтэй ба тус зээлийг 2019 онд “Чандмань - Баянхонгор” ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэсэн байна.

Цаашид тус өглөгийг барагдуулахад төсвийн ачаалал нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй тул зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавихыг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад зөвлөмжөөр 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжээгүй байна.

Иймд цаашид тус зээлийн үлдэгдлийг хэрхэн барагдуулах талаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай байна.

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК:

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК нь 2019-2021 онд нийт 140,740.4 мян.кВтц цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөж гүйцэтгэлээр 12,784.4 мян.кВтц цахилгаан эрчим хүч буюу 9.1 хувиар илүү худалдан авсан байна.

Хүснэгт 19. "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК-ийн 2019-2021 оны ЦЭХ-ний төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

Үзүүлэлт	х/н	2019		2020		2021	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ХАЦЭХ-ны зардал	сая.төг	5,593.80	5,998.40	6,176.20	7,185.40	7,686.50	8,297.20
ХАЦЭХ	мян.кВт.ц	42679.2	44657.3	44350	49,584.80	53,711.20	59,282.70
Харьцаа 1/2	төг	0.131	0.134	0.139	0.145	0.143	0.140

Эх сурвалж: Баянхонгор эрчим хүч ЦТХХК-ны Үйл ажиллагааны төлөвлөгөө, Санхүүгийн тайлан

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК 2019 онд 95.0 сая төгрөгийн алдагдалтай, 2020 онд 5.5 сая төгрөгийн ашигтай, 2021 онд 415.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь 2021 оны 12 дугаар сарын цахилгааны бичилтийн хугацааны давтамжид өөрчлөлт орсонтой холбоотой борлуулалтын орлого дараа онд бүртгэгдсэнтэй холбоотой байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын "Баянхонгор-Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх захиралтай 2021 онд байгуулсан "хамтран ажиллах гэрээ"-нд "Байгууллагын санхүүгийн тайлан тэнцэл, мэдээ судалгаанд үндэслэн тэдгээрийн менежментийн байдал, үйлдвэрлэл, технологи, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтэд улирал, хагас бүтэн жилээр судалгаа шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно" гэж заасан байхад байгууллагын үйл ажиллагааны тайланд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд судалгаа, шинжилгээ хийсэн талаарх мэдээлэл байхгүй байна.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Иймд цаашид үйлдвэрийн санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээ хийж дүгнэлт хийж үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

Шинэжинст сумын “Тохижилт үйлчилгээний алба” УТҮГ нь 2021 онд 76.0 сая төгрөгийн ашигтай гарсан ба энэ нь уул уурхайн аж нэгжүүдээс орж ирсэн 132.7 сая төгрөгийн хандивын орлогоос 56.7 сая төгрөгийг зарцуулсантай холбоотой, 2022 оны 1 дүгээр сард үлдэгдэл мөнгийг ОНО-д төвлөрүүлсэн байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 49,020.6 сая төгрөгийн хөрөнгөтэй байгаагаас нийт хөрөнгөөс 2.2 хувийн алдагдал хүлээж байна.

Хүснэгт 20. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны хөрөнгийн өгөөж

Хуулийн этгээдийн нэр	Нийт хөрөнгө /сая.төг/			Хөрөнгийн өгөөж /хувиар/		
	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	19,313.5	20,942.9	20,841.6	(0.5)	0.0	(2.0)
"Чандмань Баянхонгор" ХК	3,353.3	7,010.1	7,205.5	4.1	(1.9)	0.9
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	3,962.5	6,122.2	5,852.2	(5.1)	(2.7)	(4.2)
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	150.3	123.0	243.6	(59.1)	(48.7)	20.2
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	7,737.5	15,414.8	14,797.2	3.8	(0.1)	(4.1)
Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ		4.5	80.5		(122.2)	94.4
НИЙТ ДҮН	34,517.1	49,617.5	49,020.6	0.1	(0.8)	(2.2)

Иймд цаашид орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, орон нутгийн өмчийн хөрөнгөөс хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлогоор хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- **Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-аас 2021 онд 105.0 сая төгрөгийн төсөл авсан 4 иргэн нь төслийг зориулалтын дагуу зарцуулаагүй төслийн үйл ажиллагааг эхлүүлээгүй байна**

Зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ын гүйцэтгэх удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

- **Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх” журмын 6.6-д заасны дагуу шаардлага хангасан төслүүдэд шинжилгээ судалгаа хийж төсөл сонгон шалгаруулах комиссын хуралдаанаар оруулах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байна.**

Цаашид журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, ирсэн төсөлд зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ, орлого зарлага, хэрэгцээ шаардлагын тооцоолол хийж төсөл сонгон шалгаруулах комиссд хүргүүлж байх зөвлөмжийг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ын гүйцэтгэх удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

- **Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн дэргэд түрээсээр үйл ажиллагаа явуулж байгаад гарсан 47 бизнес эрхлэгчийн нэгдсэн судалгаанаас харахад 16 бизнес эрхлэгч л бойжиж үй ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна.**

Цаашид Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн засаглалыг сайжруулж бойжуулж буй төсөл хөтөлбөр, бизнесүүдэд чиглэсэн мэргэжилт арга зүйн сургалт, судалгаа, дүн шинжилгээ илүү системтэй боловсруулан компанийн үндсэн зорилго, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжийг компанийн ТУЗ-д хүргүүлэв.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь Компаний тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий гэрээ байгуулаагүй байна.

Харин Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/12 дугаар “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг баталж хөгжлийн төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Баянхонгор аймгийн нутагт уул уурхайн



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

ашиглалтын лиценз эзэмшигч 15 аж ахуйн нэгжтэй “Орон нутгийн хамтын ажиллагаа”-ны гэрээний хэрэгжилтээр санхүүжүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Тус хөрөнгө оруулалтаас орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд 2021 онд дараах хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

“Шинэжинст тохижилт үйлчилгээний алба” УТҮГ

Баянхонгор аймаг, Шинэжинст, Баян-Өндөр сумын байгаль орчныг хамгаалах, уул уурхайн ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, тухайн орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр ард иргэдийн амьдрах орчныг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан гэрээний дагуу 132.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын илрүүлэлт:

“Эрдэнэ Монгол” ХХК-иас 2021 онд “Шинэжинст тохижилт үйлчилгээний алба” УТҮГ-ын харилцах дансанд 132.7 сая төгрөгийн хандив авч 56.7 сая төгрөгийг ЗДТГ-ын байрны урсгал засвар, Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, сургалтын хоол, зураг төсөөт зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 25.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд гэрээний дагуу орох санхүүжилтийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, сум орон нутагт ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төсөл арга хэмжээг төлөвлөн сумын ИТХ-ын тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх зөвлөмжийг сумдын ИТХ-ын даргад хүргүүлэв.

“Баянхонгор хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр Баянхонгор Хот тохижилт ОНӨААТҮГ-т 2021 онд 191.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаас явган замын хавтангийн үйлдвэрлэлтэй холбоотой 61.8 сая, ойн зурвасын хашаажуулалд, усалгааны системийг шинэчлэхэд 90.2 сая, тохижилт үйлчилгээний ажилд 39.5 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авсан байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар явган замын үйлдвэрийн угсралт, тээвэрлэлтийн зардал 16.1 сая, тээврийн зардал 8.9 сая төгрөгийг өртөгт оруулаагүй, ойн зурвасын хашаажуулалд, усалгааны материал 65.9 сая, цэцгийн мандлын өнгөлгөөний материал 12.9 сая, багаж хэрэгсэл 2.5 сая нийт 81.3 сая төгрөгийн материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 заалтыг зөрчсөн байна.

Иймд үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг хөрөнгө оруулагч компаниудаар бараа материалын үнэлгээ хийлгэж, нягтлан бодон бүртгэлд бүртгэх албан шаардлагыг Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

2.4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК, “Чандмань Баянхонгор” ХК, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ууд Төлөөлөн удирдах зөвлөлтэй ба 2019-2021 онд ТУЗ-ын зардалд 168.1 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 115.9 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК 73.1 сая, Чандмань Баянхонгор” ХК 40.3 сая төгрөгийг ТУЗ-ын зардалд зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 21. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны ТУЗ-ын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

Хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	33.1	27.7	33.1	20.6	33.4	24.8
"Чандмань Баянхонгор" ХК	16.8	12.6	19.2	13	19.4	14.7
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	4.5	0.3	5.2	0.9	3.5	1.3
Нийт	54.4	40.6	57.5	34.5	56.3	40.8



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх удирдлагын цалинг авч үзвэл "Баянхонгор эрчим хүч" ЦТХХК, "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-уудын цалинг ТУЗ-өөс тогтоож өгч байгаа бол "Баянхонгор-Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх захирлын цалинг аймгийн Засаг даргын захирамжаар төрийн албан хаагчийн цалингийн шатлалаар цалинжуулж байна.

Харин "Чандмань Баянхонгор" ХК нь 2019-2021 онд дэд захирлын орон тоотой ажиллаж байсан ба 2022 оны 6 сараас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж тус албан тушаалыг байхгүй болгосон байна.



"Баянхонгор-Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх захиралтай байгуулсан "2021 онд хамтран ажиллах гэрээ"-3.3-д "Гүйцэтгэх захиралд олгох цалин хөлс, бусад шагнал, нэмэгдэл урамшууллыг холбогдох хууль дүрмийн хүрээнд олгоно" гэж заасны дагуу цалингийн хэмжээг Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын ТҮ-9 зэрэглэлийн 4 болон 5 дахь шатлалаар цалинг тооцож олгосон байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2019-2021 онд ТУЗ-өөс батлагдсан бүтэц орон тоонд багтаан ажиллах хүчний нөөцийг бүрдүүлж ажилласан байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар эрх бүхий этгээдээс орон нутгийн өмчид хуулийн этгээдүүдийг нийт 312 орон тоотой байхаар баталж өгснөөс гүйцэтгэлээр 309 орон тоотой ажилласан байна. Энэ нь өмнөх оноос 27 орон тоогоор нэмэгдсэн нь "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын орон тоог 35 орон тоогоор нэмэгдүүлж төлөвлөсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 22. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	93	93	93	93	94	94
"Чандмань Баянхонгор" ХК	82	83	84	84	82	82
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	17	15	15	15	17	16
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	42	41	42	40	45	44
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	45	45	45	45	69	68
Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ			5	5	5	5
Нийт	279	277	284	282	312	309



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Аудитад хамрагдсан 2019-2021 онуудад орон нутгийн өмчит хуулийн этгүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулахад ажиллагсадын цалин, нийгмийн даатгалын зардалд нийт 9,367.9 сая төгрөгийн зардалыг холбогдох эрх бүхий хуулийн этгээдээс баталж өгснөөс гүйцэтгэлээр 9,095.0 сая төгрөгийн зарцуулсан байна.

Хүснэгт 23. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

Хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	1,223.2	1,122.8	1,313.0	1,203.2	1,313.0	1,320.8
"Чандмань Баянхонгор" ХК	779.0	764.2	985.7	914.5	962.3	948.5
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	91.1	76.5	109.5	104.7	122.9	122.8
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	334.4	350.4	361.8	400.8	461.7	456.7
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	326.7	326.7	368.5	368.3	579.8	579.0
Шинэжинст сумын "Тохижилт үйлчилгээний алба" УТҮГ			23.4	23.4	11.8	11.8
Нийт	2,754.4	2,640.5	3,162.0	3,014.9	3,451.5	3,439.6

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ

Аймгийн Засаг даргын 2021.02.17-ны өдрийн А/125 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тооны хязгаарыг 69 орон тоогоор буюу өмнөх оноос 24-өөр нэмэгдүүлэн баталсан ба гүйцэтгэлээр 68 албан хаагч ажилласан байна.

Захиргаа удирдлагын хэлтэст-3, ногоон байгууламжийн албанд-7, нийтийн үйлчилгээний албанд 9, тохижилт үйлчилгээ техникийн албанд 6 ажилтан шинээр ажилд орсон байна. Ландшафт архитектор, ХАБЭА, хотын соёл хариуцсан мэргэжилтэн, менежерийн ажлын байрны тодорхойлолт байхгүй, орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин, НДШ -ийн зардал өмнөх оноос 210.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цаашид нэмэгдсэн ажиллагсдыг 2021 оны 3 сараас эхлэн ажилд авсан тул 2022 оны төсөвт цалингийн зардал өсөх эрсдэлтэй байна.

Иймд ажлын байрны давхардал байгаа эсэх талаар судалгаа хийж байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөн батлуулж, хэрэгжүүлэх албан шаардлагыг Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн орон нутагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрт 300.0 сая төгрөг батлагдснаас явган замын хавтан үйлдвэрлэлийн автомат тоног төхөөрөмжийг 125.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр "Буянт хөрс наран" ХХК шалгарч тоног төхөөрөмжийг Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн байна.

Дээрх хөрөнгийн эзэмшигчийг тогтоолгох хүсэлтийг Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2021.12.27-ны өдрийн 5/1930 дугаар албан бичгээр хүргүүлсэн ч аймгийн ИТХ-аас хөрөнгө эзэмшигчийг тогтоосон тогтоол гараагүй байна.

Явган замын хавтан, блок, өнгөт хавтан үйлдвэрлэхэд шаардагдах 120 тн цемент болон тоног төхөөрөмжийн тээврийн зардлыг уул уурхайн компаниудаас оруулах хөрөнгө оруулалтын гэрээний дагуу шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймагт явган замын хавтан, блок, өнгөт хавтан үйлдвэрлэх ажлыг аймгийн Зэвсэгт хүчний дугаар ангитай гэрээ байгуулан 2021.08.04-2021.08.24-ны



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

хооронд гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын хөлсийг 22.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар замын хавтан, блок, өнгөт хавтан үйлдвэрлэх ажлыг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд гэрээт 10 ажилтнаар 2022.04.20-аас гүйцэтгүүлж байгаа боловч ямар нэгэн гэрээ байгуулаагүй,

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалт хангалтгүй, үйлдвэрээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг харилцагчдад олгохдоо эрх бүхий албан тушаалтын зөвшөөрөлгүй олгож байгаа нь бүртгэлээр тавих хяналт байхгүй байна

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд 10 ажилтантай холбогдох гэрээг байгуулах, түүхий эд, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтыг сайжруулах, үйлдвэрээс бүтээгдэхүүнийг харилцагчдад олгохдоо тодорхой журам боловсруулан зөвшөөрлийн дагуу олгож, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

Аудитаар тус үйлдвэрийн үйлдвэрлэсэн 18956 ш бүтээгдэхүүнийг 88.8 сая төгрөгөөр үнэлэн бүртгэснийг дахин тооцоолж үзэхэд 74.8 сая төгрөгийн зардал гарсан байхад 14.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Иймд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг НББОУС-ын дагуу тооцож нягтлан бодох бүртгэлд өртгийг хуримтлуулан бүртгэх албан шаардлагыг Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Тус байгууллага нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой холбогдох сатндарт, "Тохирлын гэрчилгээ"-г Стандартчил хэмжил зүйн газраас аваагүй, "Технологийн заавар"-ыг Барилга, хөгжлийн төвөөр баталгаажуулаагүй, явган замын хавтангийн сорьцын лабораторын шинжилгээг ГХБХБГ-ын лабораториар шинжлүүлсэн ба бусад бүтээгдэхүүнийг сорьцын лабораторын шинжилгээг хийлгээгүй байна

Иймд үйлдвэрлэх бүтээгдэхүүний сорьцийн лабораторын дүгнэлт, тохирлын гэрчилгээ, технологийн зааврыг боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ажиллах зөвлөмжийг Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлэв.

ЗОРИЛТ ГУРАВ: ОРОН НУТГИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1. Төрийн байгууллагуудаас санхүүгийн хяналтыг хангалттай түвшинд хэрэгжүүлж байгаа ч компанийн засаглал, үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд санхүүгийн хяналтыг хэрэгжүүлж байгаа ба аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчид хийх хяналтыг бүртгэлээр хэрэгжүүлж байна.

Харин компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, үр дүнд чиглэсэн хяналт шалгалтыг төрийн байгууллагуудаас хийгээгүй байна.

Төрийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудит:

Төрийн аудитын газар нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд аудит хийж санал дүгнэлт өгсөн.

Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК, "Чандмань – Баянхонгор" ХК - уудын 2019-2021 оны санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт, "Цэвэр хот" ОНӨААТҮГ, "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2020, 2021 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", "Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба"



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 2021 оны санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 24. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлт

Хуулийн этгээдийн нэр	2019	2020	2021
“Цэвэр хот” ОНӨААТҮГ	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Хязгаарлалттай
Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Хязгаарлалттай
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХК	Зөрчилгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай
Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК	Зөрчилгүй	Зөрчилгүй	Зөрчилгүй
Чандмань - Баянхонгор ХК	Зөрчилгүй	Зөрчилгүй	Зөрчилгүй
Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба УТҮГ	-	Хязгаарлалттай	Сөрөг

Санхүүгийн тайлангийн аудитаар 2019-2021 онд нийт 2.832.1 сая төгрөгийн 87 алдаа зөрчил илрүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 25. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Хуулийн этгээдийн нэр	2019		2020		2021		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Цэвэр хот” ОНӨААТҮГ	2	3.9	7	79.1	5	253.5	14	336.5
“Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ	5	8.7	7	404.2	8	250.1	20	662.9
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК	3	227.1	2	255.1	8	484.0	13	966.2
Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК	2	133.1	2	-	6	57.1	10	190.2
Чандмань - Баянхонгор ХК	7	239.0	7	190.3	4	75.7	18	504.9
Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба УТҮГ			7	30.8	5	140.4	12	171.2
НИЙТ ДҮН	19	611.8	32	959.4	36	1,260.9	87	2,832.1

Татварын хэлтсээс хийсэн хяналт шалгалт:

Аймгийн Татварын хэлтсээс “Цэвэр хот” ОНӨААТҮГ -ын 2016.01.01-2019.12.31 хүртэлх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт, шалгалтыг 2020.11.11-2020.11.17-ны хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Тус шалгалтаар цалин хөлстэй холбоотой 22.5 сая, борлуулалтын орлоготой холбоотой 14.7 сая нийт 37.5 сая төгрөгийн зөрчил илэрч 4.1 сая төгрөгийн нөхөн татвар, 1.2 сая төгрөгийн торгууль, 1.9 сая төгрөгийн алданги нийт 7.2 сая төгрөгийн төлбөр төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

“Цэвэр хот” ХХК -ийн статусаар үйл ажиллагаа явуулах хугацаанд 2014.11.12-2018.04.25 ны хооронд НӨАТ төлөгч байсан бөгөөд НӨАТ-ын буцаан олголтын 2.1 сая төгрөгийн авлага одоо болтол барагдуулаагүй дансанд бүртгэлтэй хэвээр байна. Төсвийн тухай хуулийг 6 дугаар бүлгийн 6.4.8 дэх заалт, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дахь заалттыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд НӨАТ-ын худалдан авалтын буцаалтыг өөр төрлийг татварыг суутган тооцох замаар барагдуулах зөвлөмжийг “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд хүргүүлж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалт:

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК, “Чандмань Баянхонгор” ХК-ийн 2019 оны, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн 2020 оны, “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2020 он, Баянхонгор тохижилт үйлчилгээний ОНТҮГ-ын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 288.5 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж зөрчлийг арилгаж давтан гаргуулахгүй байх 70 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 26. ОНӨ-т хуулийн этгээдийн 2019-2021 оны хяналт, шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил

Санхүүгийн хяналт аудитын албаны хяналт шалгалт	Төлбөр зөрчлийн дүн /сая.төг/	Өгсөн зөвлөмжийн тоо
---	-------------------------------	----------------------



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	182.7	28
"Чандмань Баянхонгор" ХК	6.0	19
"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК	0.9	4
"Цэвэр хот" ОНӨААТҮГ	82.4	6
"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	16.5	13

3.2. Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын болон дотоод хяналтын тогтолцоо төлөвшөөгүй, хяналтын үр дүнг тооцох боломжгүй байна.

Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын дэргэд дотоод аудитын хороо нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа шалгахад хороодын үйл ажиллагаа нь жигдрээгүй, аудитын хорооны ажлын үр дүнг тооцсон эсэх нь тодорхойгүй байна.

Аудитын илрүүлэлт:

"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК-ийн ТУЗ-ын дэргэд дотоод аудитын хороо байхгүй "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-уудын ТУЗ-ын дэргэд аудитын хороог байгуулж хорооны ажиллах журмыг баталсан ч тус хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4 -т заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ТУЗ-д танилцуулсан талаар хангалттай нотлох баримт байхгүй байна.

Иймд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг Компанийн тухай хуульд нийцүүлэн байгуулж үйл ажиллагааны үр дүн тооцож ажиллах зөвлөмжийг "Баянхонгор эрчим хүч" ЦТХХК, "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-уудын ТУЗ-д хүргүүлэв.

"Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-уудын гүйцэтгэх захирлын дэргэд дотоод хяналт хариуцсан албан тушаалтныг томилж дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг баталсны дагуу дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулан дотоод хяналтыг хэрэгжүүлж үнэлгээ хийж байгаа боловч үр дүнг хэлэлцэж, алдаа дутагдлыг сайжруулах ажил зохион байгуулаагүй байгаа нь хяналт шалгалтын үр дүн, үр нөлөө гараагүй байна.

Иймд дотоод хяналт хариуцсан албан тушаалтны ажлын үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг "Чандмань Баянхонгор" ХК, "Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ын гүйцэтгэх захирлуудад хүргүүлэв.

"Цэвэр хот" ОНӨААТҮГ

Гүйцэтгэх захирлын 2021.03.02-ны өдрийн "Тээврийн хэрэгсэл, баримт бичгийн ашиглалт, бүрэн бүтэн байдал, багаж хэрэгсэлд үзлэг шалгалт хийх тухай" А/13 дугаар тушаалаар ээврийн хэрэгсэл, баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг шалгах ажлын загварыг, 2021.03.09-ны өдрийн "Ажлын байрны эрсдлийн үнэлгээний ажлын хэсэг байгуулах тухай" А/14 дугаар тушаалаар эрсдлийн үнэлгээний холбогдох маягтын баталсан байна. Мөн 2021.09.29-ний өдрийн "Газрын орлого бүрдүүлэлт, гэрээ, тайлан мэдээнд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах тухай" А/28 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамжийг баталж тушаалын хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ

Гүйцэтгэх захирлын 2021.06.14-ний өдрийн 75 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Мөн өдрийн 76 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын журмыг баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Тус байгууллагад дотоод хяналтын тогтолцоо иж бүрэн тогтоогүй, стратеги болон бизнес төлөвлөгөө боловсруулаагүй нь тухайн жилд ямар зорилго, зорилтод хүрэх нь тодорхойгүй, байгууллагын удирдлага нь хууль тогтоомжийн хэрэгжилт хир үр дүнтэй,



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

өгөөжтэй үйл ажиллагаа явуулах, найдвартай санхүүгийн тайлагналттай байх баталгааг хангахын тул хяналтын үйл явцыг бүрэн хэрэгжүүлээгүй.

Дотоод хяналт шалгалтыг 2021 онд нэг удаа зохион байгуулсан бөгөөд байгууллагын захирлын баталсан удирдамжийн дагуу албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтад дотоод хяналт шалгалтын хийж гүйцэтгэсэн ч удирдамжид тусгагдсан зарим хяналтыг хийж гүйцэтгээгүй байна.

3.3. Шинээр үүсгэн байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлээгүй, түүнд тавих хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь үйл ажиллагааны тайлангаа аймгийн ЗДТГ-ын холбогдох бодлогын хэлтсүүдэд нэгтгүүлж төрийн байгууллагуудад мэдээллээ тогтмол хүргэж байна.

"Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-иас зээл авсан зээлдэгчдийн зээлийн мэдээллийг Монгол банканд хүргүүлж зээлийн мэдээллийн санд мэдээллийг нэгтгүүлэхгүй байгаа ба Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд хүргүүлж байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-иас төслүүдийг санхүүжүүлэхдээ бизнесийн зах зээлийн судалгааг төрийн байгууллагуудад хүргүүлж төслийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж бүх салбарыг тэгш хүртээмжтэй хангаж чадахгүй байна.

Цаашид бизнес, зах зээлийн судалгааг гаргаж, орон нутгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан тэргүүлэх чиглэлийг жил бүр тодорхойлон төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлж байх зөвлөмжийг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн ТУЗ-д өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь мэдээллийн ил тод байдлыг дараах нийтлэг байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг ТБОНӨБАУХАТ хуулийг хэрэгжүүлэн цахимаар tender.gov.mn сайтаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын шилэн дансны цахим сайтад байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг тухай бүр шилэн дансны цахим сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан.

Байгууллагын мэдээллийн самбарт үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, шинээр гарсан дүрэм журам, сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг, байгууллагын фэйж хуудсаар өдөр тутмын болон онцлог үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод мэдээлж хэвшсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь байгууллагын мэдээлэл дамжуулах ил тод байдлын журам боловсруулаагүй,

Дүрэмд ТУЗ, ажиллагсад, хэрэглэгчдэд болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах талаар тусгасан заалт байхгүй,

Байгууллагын мэдээллийн "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК-аас бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нууц болон бусад байдлаар ангилаагүй байна.

Иймд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн / 2022.05.01-ээс хүчин төгөлдөр болсон/ 8 дугаар зүйлийн 8.6.5, 8.6.6, 8.6.8 заалтыг хэрэгжүүлж нээлттэй мэдээллийг хэрхэн олон нийтэд хүргэх талаар дүрэмд өөрчлөлт оруулж ажиллахыг ТУЗ болон гүйцэтгэх захирал нарт зөвлөмжөөр хүргүүлэв.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

“Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ нь мэдээлэл дамжуулах ил тод байдлын журам боловсруулан ажиллаагүй байна. Байгууллагын үйл ажиллагааг орон нутгийн ТВ болон төрийн байгууллагад сургалтаар мэдээлэл хийгдэж байна. Харин байгууллага дээр санхүүгийн ил тод байдлын самбар байхгүй мөн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй шилэн дансны цахим хуудаст байгууллагын талаар мэдээлэл өгч бүртгүүлээгүй, мэдээлэл байршуулж ажиллаагүй байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв”-ийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

“Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

“Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” нь 2021 онд хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний зардалд шаардлагатай эм, эмчилгээний хэрэгслийг худалдан авах гэрээг “Ази фрам” ХХК, “Наян булаг ганга” ХХК-тай шууд байгуулж 67.2 сая төгрөгөөр, эмчлүүлэгчдийг хоол, хүнсээр хангах гэрээг “Явуу Хэлхээ” ХХК-тай шууд байгуулж 35.4 сая төгрөг зарцуулсан байна.

Цаашид батлагдсан төсвийн дагуу ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв”-ийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

Аудитаар нийт **4,105.1** сая төгрөгийн 33 алдаа, зөрчил илрүүлж **45.5** сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, **302.9** сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага өгч, **3,756.7** сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 20 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын засаглалын талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй, засаглалыг үнэлэх тогтолцоо хангалтгүй байна.
2. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа хууль, тогтоомжид нийцүүлээгүй, шинээр үүсгэн байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлээгүй байна.
3. Баянхонгор аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого байхгүй, төрийн байгууллагуудаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.
4. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана гэсэн зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна.
5. Орон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ТУЗ-ийн болон дотоод хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.
6. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг хуульд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.
7. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь 2019-2021 онд нийт 1,416.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвийн хөрөнгийн үр өгөөж гараагүй, зарим аж ахуйн нэгжийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

_____оОо_____



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГАД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь өөрийн үйл ажиллагаагаар орлого байхгүйгээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна.
2. Орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийг хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэхэд ИТХ-аас хяналт тавьж, үр дүнг тооцоогүй байна.
3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, орон нутгийн өмчийн хөрөнгөөс хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлогоор хангаж ажиллах шаардлагатай байна.
4. “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ын зардал цаашид нэмэгдэхэд орон нутгийн төсөвт хүндрэл учрах эрсдэлтэй байгаа тул эрүүл мэндийн салбарт шилжүүлэх асуудлыг судалж үзэх шаардлагатай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. “Чандмань Баянхонгор” ХК -ийн хөрөнгөд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглалтгүй байгаа Хонгор-1000 хорооллын 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн үр ашгийг гаргаж эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах

СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА НАРТ:

1. Сум орон нутагт хууль зөрчин үр ашиггүй орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж уур уурхайгаас хандивын орлогыг төвлөрүүлэн зарцуулдаг байдлыг таслан зогсоох.
2. Орон нутагт ямар нэгэн хэлбэрээр орж байгаа хандивын орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-ын санд төвлөрүүлж байх.

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ТУЗ-ЫН ДАРГА НАРТ:

1. Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргыг сургалтад бүрэн хамруулах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг Компанийн тухай хуульд нийцүүлэн байгуулж үйл ажиллагааны үр дүн тооцож ажиллах.
3. Компанийн алдагдлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлэх судалгаа шинжилгээ хийж, дунд болон богино хугацааны стратеги төлөвлөгөө гарган орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж гүйцэтгэх удирдлагатай хариуцлагын гэрээ байгуулж ажиллах

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГУУДАД:

1. Байгууллагын дотоод хяналтын нэгж, хариуцсан албан тушаалтан нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, ажлын үр дүнг тооцож ажиллах.

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтын саналыг хянаж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ:



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг бүртгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлага хангасан эсэхийг хянаж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ХХК-ИЙН ТУЗ-Д:

1. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн засаглалыг сайжруулж бойжуулж буй төсөл хөтөлбөр, бизнесүүдэд чиглэсэн мэргэжил арга зүйн сургалт, судалгаа, дүн шинжилгээг илүү системтэй боловсруулан компанийн үндсэн зорилго, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
2. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК -аас олгох төслүүдийг бизнес, зах зээлийн судалгааг, орон нутгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан тэргүүлэх чиглэлийг жил бүр тодорхойлон эрэмбэлэн санхүүжүүлж байх.

“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД:

1. Ахуйн үйлчилгээний төвийн барилгын өрөөнүүдийн талбайн хэмжилтийн зургийг хийлгэж түрээслэгчидтэй байгуулсан гэрээний талбайн хэмжээг баталгаажуулах.
2. Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх” журамд заасан чиг үүргээ “...ирсэн төсөлд зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ, орлого зарлага, хэрэгцээ шаардлагын тооцоолол хийж төсөл сонгон шалгаруулах комиссд хүргүүлж байх” гэсэн хэрэгжүүлж ажиллах.

“БАЯНХОНГОР-ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД:

1. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний сорьцийн лабораторын дүгнэлт, тохирлын гэрилгээ, технологийн зааврыг боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ажиллах.
2. Үйлдвэрийн санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээ дүгнэлт хийж үр дүнг тооцож ажиллах.

“ЦЭВЭР ХОТ” ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД:

1. НӨАТ-ын худалдан авалтын буцаалттай холбоотой авлагыг өөр төрлийн татварын төлбөрт суутган тооцох замаар барагдуулах

оОо